

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ” ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Ундны усны эх үүсвэрт хууль бусаар газар олголт хийгдэх
захиргааны хэм хэмжээний акт гарснаар ард иргэдийн хууль
ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна.**

АУДИТЫН КОД:ХОА-2021 /117/-ШТА- НА

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Галбадрах
Утас: 99084291 Цахим хаяг: Galbadrakh.L@audit.gov.mn
Аудитор: Д.Балжинням
Утас:7043-2545 Цахим хаяг:Baljinnyam.d@audit.gov.mn

Ховд хот 2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Товчилсон үгийн тайлбар	3
Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, хязгаарлалт, арга зүй, үндсэн мэдээлэл, хүндрэл бэрхшээл	4-5
БҮЛЭГ 1. Хууль бус газар олголт хийгдэж хуулийн хэрэгжилт хангагдаагүй, усны бодлогод сөргөөр нөлөөлж байна.	6
1.1. Ховд аймгийн усны нөөцийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна.	6
1.2. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд газар олгосон байна.....	7
1.3. Аймгийн усны мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлээгүй, нэгдсэн мэдээллийн олдоц хангалтгүй байна.	9
1.4. Сав газрын захиргаанаас хийгдсэн усны тооллогын мэдээлэл зөрүүтэй, чанаргүй хийгдсэн байна.....	9
1.5. Хүн амын унд ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн бохир усыг бүрэн цэвэршүүлж чадахгүй байна.....	10
1.6. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжүүд шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.....	10
Бүлэг 2. Ус рашааны нөөц ашигласны төлбөр төлөх эрх зүйн зохицуулалт хангагдсан боловч, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	11
2.1 Иргэн, аж ахиун нэгжүүд ус ашиглуулах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулахгүйгээр ус ашиглаж байна.	11
2.2. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл хангалтгүй байна.	12
2.3 Ус бохирдуулагч хуулийн этгээдийг бүрэн хамруулж төлбөр ногдуулаагүй байна.....	13
2.4. Усны төлбөр хураамжийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй байна.....	14
2.5. Усны орчныг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг бий болгоход анхаарах шаардлагатай байна.....	14
БҮЛЭГ 3 Хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт хийгдээгүй тул үр нөлөөг тооцох боломжгүй байна.....	15
3.1 Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, ЗД, БОАЖГ хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.....	15
3.2. Ус ашиглагчийн ус авах цэг, газар доорх усны цооног, шугамын оролт бүрийг тоолууржуулах шаардлагатай байна.....	16
3.3. Худаг уст цэгийг паспортжуулаагүй байна.....	16
Аудитын дүгнэлт: Ундны усны эх үүсвэрт хууль бусаар газар олголт хийгдэх захиргааны хэм хэмжээний акт гарснаар ард иргэдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна.	
Зөвлөмж	17

Холбогдох байгууллагын санал.19**ТОВЧИЛСОН ҮГ**

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНМАУ	Бүгд найрамдах Монгол ард улс
ХХК	<i>Хариуцлагатай хувьцаат компани</i>
БЦГ	Байгалийн Цогцолборт газар
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоон үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2021 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Усны тухай хуулийн хэрэгжилтэд” нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт: Усны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.

Аудитын хамрах хүрээ: Аудитыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, БОАЖГ, Хар-Нуур Ховд голын сав газрын захиргаа, Үенч Бодонч, Булган голын сав гарын захиргаа, Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргаа, Татварын хэлтэс зэрэг төр захиргааны байгууллагуудыг хамруулан усны төлбөрийн орлогын төлөвлөлт, ногдуулалт, төвлөрүүлэлт, тайлагналтай холбоотой баримт материалууд, хяналт хийгдсэн тайлан болон холбогдох тооцоолол, судалгаа, дүн шинжилгээ, бусад баримт, мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитад усны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааг аудитын дэд зорилтод хамаарах асуудлын хүрээнд хийсэн.

Аудитын дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусгагдаагүй бусад чиглэлээр үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго агуулаагүй болно.

Аудитад 2018-2020 оны үйл ажиллагааг шалгаж буй асуудлын онцлог байдлаас шалтгаалан тодорхой асуудлаар өмнөх болон дараа онуудын үйл явдал, анхан шатны баримт, данс тооцоо холбогдох мэдээллийг хамрууллаа.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 4000-4200 дугаар стандарт, Нийцлийн аудитын журмыг ашигласан бөгөөд усны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилладаг байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтэн, сумдын байгаль хамгаалагч, татварын байцаагч холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, татварын хэлтэс болон төрийн сангийн орлогын мэргэжилтнээс түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн талаарх тоо, мэдээ, судалгааг гаргуулан авч, татвар хураамжийн ногдуулалт, бүрдүүлэлттэй тулган баталгаажууллаа.

Аудитаар ус ашиглагч аж ахуйн нэгж хуулийн этгээдэд гаргасан дүгнэлт, зөвшөөрөл, усны төлбөрийн орлогын төлөвлөлт, ногдуулалт, төвлөрүүлэлт, тайлагналтай холбоотой баримт материалууд, хяналт хийгдсэн тайлан болон холбогдох тооцоолол, судалгаа, дүн шинжилгээ, бусад баримт, мэдээлэлд тулгуурлан аудитын дүнд үндэслэн дүгнэлт гарган, зөвлөмж өглөө.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов. Үүнд:

Монгол улсын үндсэн хууль, Усны тухай хууль, Рашааны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, Ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, “Ус”-үндэсний хөтөлбөр, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэр, Засаг даргын захирамж эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актууд

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Ховд аймгийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн явцын хяналт

тавьж, ахлах аудитор Л.Галбадрах, аудитор Д.Балжинням, Б.Должинжав нар 2021 оны 05-р сарын 19 - нөөс 09-р сарын 15-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитаар томилогдсон баг Чандмань, Зэрэг, Манхан, Цэцэг, Буянт, Мянгад сум, Жаргалант суманд ажиллан усны тухай хуулийн хэрэгжилт, ус рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлд хяналт хийж ажиллалаа.

Хүндрэл бэрхшээл : 2021 оны 06 дүгээр сарын 13-ны өдөр аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст албан тоотоор усны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний ажлын төлөвлөгөө, тайлан мэдээг ирүүлэхийг хүссэн боловч хариу ирүүлсэнгүй.

Мөн Ковид -19 цар тахал өвчний тархалт нэмэгдсэнтэй холбоотой газар дээр очиж хяналт хийх боломж хомс, холбогдох албан тушаалтнууд, иргэд, ААН-үүдтэй уулзаж ярилцах боломж хязгаарлагдмал, аудитын явцад олж цуглуулсан баримт, мэдээлэл, судалгаанд олон талын дүн шинжилгээ хийхэд хүн хүч бага, аудиттай холбоотой байгуулсан гэрээ, хяналтын тайлан зэргийг цаг хугацаанд нь гаргаж өгөхгүй зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байлаа.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 сарын 30-ны А/324 дүгээр захирамжийн дагуу усны тооллогоор Ховд аймгийн 17 сумын 91 багийн нутаг дэвсгэрт явуулсан усны тоо бүртгэлийн дүнгээр 217 гол, 658 булаг шанд, 108 нуур, 28 рашаан, худаг 643, 6 үерийн хамгаалалтын далан, 4 усан цахилгаан станц, 14 услалтын систем, 2 цэвэрлэх байгууламж тус тус тоологдсон байна.

Ус зүйн сүлжээний хувьд Хар-Нуур Ховд голын сав газрын захиргаа, Үенч Бодонч, Булган голын сав газрын захиргаа, Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргаанд Гурван сав газрын захиргаанд хамаарагддаг байна.

Аймгийн хэмжээнд 2 дулааны станц, 120 гаруй усан халаалтын зуух ажиллаж байна.

217 гол горхи тоологдсоноос түр горимын 16, байнгын урсацтай 201 гол, 658 булаг шанд тоологдсоноос устай 643, түр горимын урсацтай 15, эхийг нь хашиж хамгаалсан булаг 10, хамгаалах шаардлагатай 18 булаг байна.

Ховд аймгийн нийт ус ашиглалт, усны хэрэглээ жилд 50 орчим сая шоо метр бөгөөд нийт хүн амын 10 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 27 хувь нь ус түгээх байр, худгаас, 63 хувь нь гүний болон гар худаг, булаг, шанд, гол горхиноос усаа авч хэрэглэж байна.

Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах, мал аж ахуйн болон газар тариалангийн тогтвортой байдлыг хангах, бэлчээр, газар тариалангийн талбайг усжуулах, хөнгөн, хүнс, уул уурхайн болон бусад үйлдвэрлэлийн салбар, сэргээгдэх эрчим хүчний салбаруудын хөгжлийг тодорхойлох үндсэн дэд бүтцийн нэг, хөгжлийн голлох хүчин зүйл болж байна.

Ус ашиглалт, усны хэрэглээнд тавих хяналт боловсронгуй бус, энэ талаарх эрх зүйн орчин, нэгдсэн мэдээлэл, хяналтын тогтолцоо хараахан бүрдээгүй байгаа нь ус ашиглалт, усны хэрэглээний мэдээллийг нарийвчлан гаргаж хянах, менежмент хийхэд хүндрэл учруулж байна.

Аймгийн төлөвлөлтөд тусгагдаагүй газар олголт, хууль бус газар ашиглалтаас үүдэн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон тэжээгдлийн мужийн дэглэм ихээхэн зөрчигдөж байна.

БҮЛЭГ 1. ХУУЛЬ БУС ГАЗАР ОЛГОЛТ НЬ УСНЫ БОДЛОГОД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛ ҮҮССЭН БАЙНА.

Ховд аймгийн усны нөөцийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

1.1. Монгол Улс усны нөөц багавтар орнуудын тоонд ордог бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай, байгалийн бүс бүслүүрийн онцлогоос хамааран усны нөөц нь жигд бус тархсан, тэжээмж багатай, ууршилт ихтэй орон юм. Тухайлбал, гадаргын усны тархцаар нь авч үзвэл 609.5 шоо км нөөцийн 380 шоо км буюу 63.4 хувь нь зөвхөн Хөвсгөл нуурт агуулагдаж байна.

Монгол улсын усны нийт нөөц гол мөрөн, нуур цөөрөм, мөнх цас мөсөн голууд болон газрын доорх усны нөөцөөс бүрддэг бөгөөд 609.5 км³ байдаг. Үүнээс газрын доорх болон гадаргын усны нөөцийг хүн ам, мал сүргийн усан хангамж, уул уурхай үйлдвэрийн усан хангамж, газар тариалан услах чиглэлээр ашиглаж байна.

Хуулийн 5.1-д Энэ хуулийн 4.4-т заасан усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ гэж заажээ.

Аймаг орон нутгийн удирдлага болон мэргэжлийн байгууллагуудад ундны усны нөөцийг шинэчлэн тогтоох хэрэгцээ шаардлагын судалгаа, тоон мэдээлэл, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө зэрэг байхгүйгээс аймгийн хэмжээний усны нөөцийг тогтоогүй байна.

1.2. Хуулийн 5.2-д “Тодорхой бүс нутгийн гидрогеологийн болон гидрологийн хайгуул судалгаа, улсын зэрэглэлтэй хот, бусад хот, тосгон, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэхээр хуульчилсан байна.

1982 онд явуулсан эрэл хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд Буянт голын хөндийн ай савын баруун талын татам болон татмын I, II дугаар дэнжийн бүсэд Ховд хотын өнөөгийн ус авах байгууламжийн дэвсгэр талбайд 62.0 л/с буюу 5356.0 м³/ хоногийн хэмжээтэй газрын доорх усны ашиглалтын нөөц баялгийг үйлдвэрлэлийн А + В зэргээр үнэлж тогтоон, тухайн үеийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Улсын Ашигт Малтмалын Нөөцийн Комиссын нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэн батлуулжээ.

Үүнээс хойш усны нөөцийг дахин тогтоогоогүй бөгөөд энэ хугацаанд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, уул уурхайн үйлдвэрлэл, хүн амын усны хэрэглээний өсөлт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зүй бус ашиглалт зэргээс шалтгаалан усны нөөц өөрчлөгдсөн байх магадлал их байна.

Монгол орны усны нөөц – Дэлхийд

Усны багавтар нөөцтэй

102	Босни-Герцеговин	37.5
103	Латви	35.45
104	МОНГОЛ	34.6
105	Азербайджан	34.6

эх сурвалж: Доктор (Ph.d), Д.Батмөнх

Монгол орны байгалийн усны нөөц

Гол, мөрөн	34.6 км ³
Нуур	500 км ³
Мөнх цас, мөсөн гол	62.9 км ³
Газрын доорх усны нөөц	12.0 км ³
Монгол орны усны нийт нөөц	609.5 км³

эх сурвалж: Доктор (Ph.d), Д.Батмөнх /Усны ассоциацийн тэргүүн/

Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд газар олгосон байна.

1.3 Хуулийн 11.1.3. Засаг даргын саналыг үндэслэн усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргах, хамгаалалтын бүсийн заагийг тогтоох, хамгаалах үүргийг аймаг, сум дүүргийн ИТХ-ын бүрэн эрхэд заасан байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 8/11 дугаар тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрт хамаарах усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн талбайн хэмжээ, хилийн заагийг, унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн худгуудын эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын бүсийн талбайн хэмжээ, эргэлтийн цэгийг баталжээ.

Дээрх тогтоолд 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11/05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж Жаргалант сумын унд, ахуйн хангамжийн эх үүсвэрийн худгуудын эрүүл ахуйн бүсийн талбайн хэмжээ, хилийг цэс хязгаарлалтын бүсийг өөрчлөн хавсралтаар баталсан байна.

Дээрх асуудал нь Нутгийн өөрөө удирдах байгууллага, Аймгийн Засаг дарга, мэргэжлийн байгууллага, ард иргэд, чөлөөт хэвлэлийн байгууллагуудын хооронд ойлгомжгүй байдал үүсэж, захиргааны хэм хэмжээний акт гарснаар ард иргэдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, шийдвэрлэх нэн тулгамдсан асуудал болоод байна.

Танай яамны зүгээс тогтоолд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэхдээ ямар нөлөөллийн шинжилгээ хийгдсэн талаарх нотлох баримтыг ирүүлнэ үү.

Аудитын илрүүлэлт:

- Усны тухай хуулийн 22 дугаар зүйл 22.4.¹, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын хавсралтын 3.9², 3.14³-д заасан заалтуудыг зөрчиж Жаргалант сумын Буюнт багийн 19 дүгээр гудамжинд 14 га газарт 350 өрхөд гэр бүлийн хэрэгцээнд зориулан шинээр газар эзэмшүүлэхээр шийдвэр гаргаж, ундны усны эх үүсвэрт суурьшлын бүс бий болгосон нь ард иргэдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн,
- Манхан, Зэрэг, Цэцэг, Чандмань, Жаргалант сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нартай уулзаж усны тухай хуулийн хэрэгжилт, хуулийн хүрээнд ИТХ, Засаг дарга нарын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн зааг тогтоох, тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, хуулийн хэрэгжилт сум орон нутагт хангалтгүй байна.

¹ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд энэ журмаар онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, бүсэд мөрдөх дэглэмийг тогтооно

² Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

³ Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх болон урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашиглавал эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан уст үеэс ус авч ашиглавал 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.

1.4.Хамгаалалтын бүсийн дэглэм, Газрын тухай хуулийн 6.2⁴-т, Хуульд өөрөөр заагаагүй бол дараах газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана” гэж заасныг зөрчиж иргэн, аж ахуйн нэгжид газар олгож эзэмшүүлжээ. Тухайлбал

- **Цамбагараев баг ойн бүсэд- 37 иргэн, аж ахуйн нэгжид 29.09 га талбайд ойжуулалт, мод үржүүлэг, жимс жимсгэнэ тарих, нөхөн сэргээх зориулалтаар газар эзэмшүүлж байна. Эдгээр газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, газар эзэмших эрх нь хүчингүй болсон, зөвшөөрөлгүй газар торлож авсан, мод тайрсан, үйл ажиллагаа явуулаагүй зэрэг 24 иргэний 18.22 га газар байна. /хавсралт 1/**

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирамж	газрын зориулалт	газры н хэмжэ э/ га/	нэгж талбарын дугаар	Ажлын хэсгийн дүгнэлт	
1	Давга	Цайрай	2012-04-16 А/71	Мод үржүүлэг	0.5	8414100883	Тортой .Газраа зориулалтын дагуу эзэмшиж байна. Газар эзэмших эрх нь хүчингүй болсон.
2	Батсүх	Алтанбадралт	2012-04-09 А/57	Ойжуулалт жимс хүлэмж	0.21	8414100906	Тортой. үйл ажиллагаа явуулаагүй
3	Жамбий	Баярсайхан	2016-05-26 А/129	Ойжуулах жимс жимсгэн	1.1	8471400578	Газраа зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй Зоорины нүх малтсан.
4	Баатар	Батчингис	2007-07-20 А/106	Ойжуулах, Жимс Жимсгэнэ тарих	1	200702565	Үйл ажиллагаа явуулаагүй. Тор унасан.
5	Ганболд	Санчирод	2009--11-09 А/139	Мод тарих Нөхөн сэргээх	0.75	200705156	Газраа зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй. Зоорины нүх малтсан.
6	Зөөлөн	Энхтайван	2009-11-09 А/139	Ойжуулах нөхөн сэргээх	0.75	200705181	Тор татсан.Газраа зориулалтын дагуу эзэмшиж байна. Газар эзэмших эрх нь хүчингүй болсон
7	Мархын	Буяндэлгэр	2009-12-14 А/163	Жимс жимсгэнэ ойжуулалт	1	200703066	Хашаа татсан. үйл ажиллагаа явуулаагүй
8	Лхагваа	Дөөддорж	2016-10-03 А/291	Мод үржүүлэг	0.28	8414000487	Эрх шилжүүлсэн.Тор татсан. үйл ажиллагаа явуулаагүй
9	Ням-Очир	Энхмандах	2016-10-03 А/291	Ойжуулах нөхөн сэргээх	0.28	8414000486	Тор татаагүй. Үйл ажиллагаа явуулаагүй.
10	Далхжав	Болормаа	2016-10-03 А/291	Ойжуулах нөхөн сэргээх	0.28	8414000488	Тор татсан. Үйл ажиллагаа явуулаагүй.Зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү
11	Зундуй	Бурмаа	2014-07-10 А/178	Нөхөн сэргээх газрыг хамгаалах ойжуулалт ногоо сэргээх жимс жимсгэнэ тариалах	0.71	8414000151	Хашаа татсан. Үйл ажиллагаа явуулаагүй.
12	Бадарч	Марина	2010-06-23 А/61	Нөхөн сэргээх, Ойжуулах	1.6	8414100064	Тор татсан. Үйл ажиллагаа явуулаагүй.
13	Лодоон	Эрдэнэ	2010-06-23 А/61	Нөхөн сэргээх, Ойжуулах	0.3	8414100030	Тортой. Үйл ажиллагаа явуулаагүй.
14	Цэнджав	Цогтбаяр	2009-12-14 А/163	Жимс жимсгэнэ мод тарих	1	8414100098	Тортой. Үйл ажиллагаа явуулаагүй.
15	Минжүүр	Дунгаамаа	2020-2-06 А/66	газрыг хамаалах, Нөхөн сэргээх	0.46	8414100902	Шинээр Э-дугаар авсан.Тортой. Үйл ажиллагаа явуулаагүй.
16	Батнасан	Гантулга	2017-09-21 А/194	Мод үржүүлэг	0.5	8414100118	Байшин барьсан. Зориулалтын бус үйл ажиллагаа яавулсан.
17	Баттулга	Сүхбаатар	2010-06-23 А/61	Нөхөн сэргээх, Ойжуулах	0.3	8414100033	Тор татсан.
18	Өлзийбаяр	Түвдэндорж	2013-06-14 А/99	ойжуулалт, цэцэгжүүлэлт	3.7	8414100052	Тор татсан.
19	Өлзийбаяр	Түвдэндорж	2016-05-26А/129	ойжуулалт, жимс жимсгэнэ	2.6	841400580	Эзэмшиж байгаа газраа зориулалт бусаар эзэмшсэн. Барилгын материал үйлдвэрлэж байсан.
20	Цродол	Машбат	2019-02-01 А/22	Мод үржүүлэгийн газар	0.28	8414007700	Тор татсан. Үйл ажиллагаа явуулаагүй
21	Монгол сафари ХХК			Мод үржүүлэгийн газар	0.12	200705120	Тортой.Мод тайрсан.Цагдаагийн байгууллагаар шалгагдаж байна.
22	Миний Сутай НҮТББ		2018-10-15 А/278	цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	0.43	8414007599	Үйл ажиллагаа явуулаагүй. Тор татаагүй.
23	Цагаанхиш Цэвээнсүрэн				0.07		Тор татаагүй. Гантулга газрын маргаантай.
24	Түргэнбаяр						Зөвшөөрөлгүй.
Нийт дүн				18.22			

ЭХ СУРВАЛЖ: ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

- **Буянт баг ойн бүсэд / усны труба дагуу / 34 албан байгууллага аж ахуйн нэгж айл өрхүүдийн 188,3 га талбайд жимс жимсгэнэ, мод тариалж байгаа боловч Буянт голоос Ховд хот руу татсан усалгааны сувгаас аж ахуйн нэгж айл өрхүүд өөрсдийн талбайдаа зориулан дур мэдэн хоолой гарган чулуу болон цементээр доторлож усан сан үүсгэн, Цагдаагийн газар, Ховд Агропарк, Зоригт, Баатар, Энхтайван, Гантогтох нар зөвшөөрөлгүй энгийн гар худаг гаргасан, /Хавсралт 2 нийт газар эзэмшигчийн нэрс /**
- **Их голын ард гүүрнээс дээш 78 иргэн, аж ахуйн нэгжид 255.7 га газрыг ойжуулалт, хадлан тэжээл, төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар эзэмшүүлж үүнээс 45 иргэний 157 га газар үйл ажиллагаа явуулаагүй байна.**
- **Ховд Агропаркийн /10га/ өнөөгийн нөхцөл байдалтай танилцахад чацаргана, алим, лиыр, гүзээлгэнэ, бургас улиасыг 7 га тариалсан. 2 төрлийн хүлэмжүүдээ тариалалт хийгээгүй шалтгаан нь хүчтэй шуурга, элсний нүүдлээс болж эвдэрсэн, /Хавсралт - 3 нийт газар эзэмшигчийн нэрс/**
- **Голын хамгаалалтын бүсэд Ховд гайд, Оцон чулуу жуулчны баазууд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. Ховд гайд Жуулчны бааз 2 га эзэмшлээр байдаг боловч зөвшөөрөлгүй 10 га талбайг торлосон,**

⁴ Хуульд өөрөөр заагаагүй бол дараах газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана: ...6.2.5.усны сан бүхий газар.

- Улсын хөрөнгө оруулалтаар Буянт голоос ус авах инженерийн хийцтэй 296 га талбай бүхий 1, Ховд гол түүний цутгал голуудад инженерийн хийцтэй 1236 га талбай бүхий 2 услалтын систем байгуулсан боловч 1990- 1995 онд их хувьчлалын үеэр услалтын системүүд хувьчлагдсан нэрээр орон нутгийн өмчид шилжин барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг тонож, ашиглах боломжгүй байгааг тоо бүртгэлд ашиглалтгүй гэдэг ангилалд бүртгэж байгаа,
- Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориголлын бүсэд Ховдын Тулга ХХК түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож байгаа зөрчил дутагдал,
- Жаргалант суманд уст цэгийн хамгаалалтын бүсийн заагийг тогтоосон боловч тэмдэгжүүлж, дэглэмийг мөрдөж ажиллаагүй байна.

Эдгээр зөрчил дутагдал нь хууль бус газар олголт хийгдэж хуулийн хэрэгжилт хангагдахгүй, эмх замбараагүй байдалд хүргэх, ундны усны эх үүсвэр болон хот төлөвлөлт, усны бодлогод сөргөөр нөлөөлж байгаад анхаарах шаардлагатай байна.

Аймгийн усны мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлээгүй, нэгдсэн мэдээллийн олдоц хангалтгүй байна.

1.5 Усны тухай хуулийн 7.3.⁵, хуулийн ⁶, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 86 дугаар тушаалын хавсралт Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмын 1.5⁷ гэж заасан аймгийн усны мэдээллийн сангийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын хугацаанд 2020 оны 06 дүгээр сарын 13-ны өдөр аймгийн БОАЖГ-т албан тоотоор усны тухай хуулийн хэрэгжилтэд бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний ажлын төлөвлөгөө, тайлан мэдээг ирүүлэхийг хүссэн боловч хариу ирүүлсэнгүй. Мөн усны тооллого хийгдэж байгаа гэх боловч ирүүлсэн тоо мэдээлэл зөрүүтэй, тооллогын нэгдсэн тоон мэдээлэл, судалгаа байхгүй дараах зөрчлүүд байна.

- Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулна гэж заасан боловч 2018 онд усны тооллого хийгдэж, хуулийн хэрэгжилт хангалтгүй,,
- Усны хуулийн дагуу тооллогыг зөвхөн тоологдсон, устай болон ширгэсэн тоо төдийхнөөр дүн мэдээ гаргаад орхиж байгаа нь учир дутагдалтай байна. Тоо мэдээнд дүн шинжилгээ хийх, ширгэсэн усны шалтгааныг тодорхойлох, ширгээгүй усны нөөц, түвшинг баримжаалах, түүнд үндэслэн авах арга хэмжээг тодорхойлохгүй байгаа нь усны тооллого хийхийн ач холбогдол, зарцуулсан санхүүгийн болон хүний нөөцийн үр ашгийг бууруулж байна.
- Хуульд мэдээллийн санг үүсгэх, хариуцах байгууллага болон өгөгдлийг бүрдүүлэх давтамжийг тодорхой зааж өгсөн боловч усны нөөц, ашиглалтын нэгдсэн мэдээллийн сан хангалттай хэмжээнд бүрдэж чадаагүй, нэгдсэн мэдээллийн олдоц хангалтгүй байна.
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй байна.

⁵ Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна

⁶ Усны мэдээллийн сан нь гадаргын болон газрын доорх ус, рашааны төлөв байдал, орон зайн үзүүлэлт, усны нөөцийн нийт болон ашиглах боломжит хэмжээ, чанар, өөрчлөлт, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалт, хаягдал ус зайлуулахтай холбогдсон мэдээ, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламжийн байршил, хүчин чадал, техникийн үзүүлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.

⁷ “Усны мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлэх ба мэдээлэл нь тоон өгөгдөл, зураг, график, бичгийн хэлбэртэй, веб орчны газарзүйн мэдээллийн системд тулгуурласан байна. Орон зайн мэдээллийг газарзүйн солбицлын градус, минут, секунд нэгжээр илэрхийлнэ

Сав газрын захиргаанаас хийгдсэн усны тооллогын мэдээлэл зөрүүтэй, чанаргүй хийгдсэн байна.

1.6. Усны тухай хуулийн 17.1.4. –д “усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах” гэж заасан байна.

Хуулиар усны тоо бүртгэлийг сав газрын хэмжээнд жил бүр зохион байгуулаагүй, мэдээллийн сан зөрүүтэй, тооллогын дүн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийгдээгүй, цаашид хийх хэтийн төлөвлөлт байхгүй байгаа нь тооллого чанаргүй хийгдэж байгаатай холбоотой байна

Хүн амын унд ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн бохир усыг бүрэн цэвэршүүлж чадахгүй байна.

1.7.Аймгийн нийтийн орон сууцанд оршин суугчид халуун, хүйтэн цэвэр ус болон бохирын сүлжээнд холбогдсон, бусад нь ус зөөвөрлөн түгээдэг хөдөлгөөнт цэг болон ус түгээх зориулалттай худгаас унд, ахуйн зориулалттай ус ашиглаж байна.

Мэргэжлийн хяналтын газар, Хар нуур –Ховд голын сав газрын захиргааны 2019 оны хамтарсан төлөвлөгөөний дагуу хүн амын ундны усны нийт 24 эх үүсвэрээс дээж авч шинжилгээ хийж шинжилгээнд хамрагдсан 22 ундны усны ерөнхий химийн үзүүлэлт нь хэвийн хэмжээнд, Үенч, Дөргөн, Дуут сумдын ундны уснаас авсан дээжээс хэвийн хэмжээнээс их үзүүлэлттэй /хатуулаг ихтэй, уран илэрсэн, кальци, магни зэрэг/ гарсан нь цаашид сумдын усны эх үүсвэрийн чанарыг сайжруулах, зөөлрүүлж, цэнгэгжүүлэх шаардлагатай байгаад зөвлөмж өгч ажилласан байна. Шинжилгээгээр дараах зөрчил илэрсэн байна

- *Ховд аймгийн ард иргэдийн байнга очиж ундны усандаа хэрэглэж байгаа Богочийн рашаанаас дээж авч лабораторийн шинжилгээ хийхэд E-coli болон халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бактери илэрсэн,*
- *Ард иргэд зөвшөөрөлгүй, нүхэн жорлонгийн түвшний хэмжээнд гар аргаар ухсан, шинжилгээгээр шаардлага хангахгүй худгаас хөрсний усыг унд ахуйдаа хэрэглэж байгаа нь өвчин үүсэх, халдварт өвчин тархах эрсдэл үүссэн,*
- *Гэр хорооллын ус түгээх байрны орчин бохирдолтой эрүүл орчны дэглэм алдагдсан, хашиж хамгаалсан хайс эвдэрсэн зөрчил дутагдал илэрч байна.*

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжүүд шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

1.8 Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Үенч, Дуут, Дөргөн, Алтай сумуудын ундны эх үүсвэрийн худгуудад усны чанарыг сайжруулах, зөөлрүүлж, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулсан ч хөрөнгө оруулалтын үр өгөөж, ашиглалт шаардлага хангахгүй байна.

- **Дуут сум:** 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Фүжи Алтай ХХК хийж гүйцэтгэсэн, ундны усны 2 худагт байршуулсан нэг дэх төхөөрөмжийн жанам шатсан, 2 дах төхөөрөмж өвөл хөлдсөн,
- **Алтай сум:** 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Од поропортес ХХК хийж гүйцэтгэсэн, ундны усны 3 худагт байршуулсан, тог цахилгааны хүчин чадал хүрэхгүй,
- **Үенч сум:** 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Од поропортес ХХК хийж гүйцэтгэсэн, ундны усны 4 худагт байршуулсан, усыг маш удаан шүүдэг, цахилгааны хэрэглээ их,

- **Дөргөн сум:** 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Фүжи Алтай ХХК хийж гүйцэтгэсэн, ус гарахгүй байгаа зэрэг шалтгааны улмаас ашиглалтгүй байна.

1.9 Аймгийн БОАЖГ нь усны тухай хуулийн 18.1.3⁸-д хуульчилсан байна. Аймгийн төвлөрсөн усан хангамж, бохир ус зайлуулах үүргийг тусгай зөвшөөрөл бүхий Шим Ус орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Зэрэг суманд Шим Ус ХХК- н хэрэгжүүлдэг боловч хаягдал усыг бүрэн цэвэрлэж чадахгүй байна. Тухайлбал:

- Ховд хотын техникийн цэвэрлэх байгууламж ачааллаа дийлэхгүй, аваарын хоолойноос бүрэн цэвэрлэгдээгүй бохир ус Буянт гол руу цутгаж хүн амын эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа,
- Зэрэг сумын цэвэрлэх байгууламж нь бохир усыг байгалийн аргаар хөрсөнд шингээдэг нягтруулсан шороон байгууламж бөгөөд 2018 оноос энэ байгууламжийн хүчин чадал нь хүрэлцэхгүй болсон, өвлийн улиралд бохир нь хальж орчныг бохирдуулдаг,
- Аймгийн сумууд төвлөрсөн халаалт, инженерийн хийцтэй шугам сүлжээнд холбогдож байгаатай холбоотой цэвэрлэх байгууламж байхгүй дур мэдэн цооног гаргаж бохир ус хуримтлуулж байгаа зөрчил дутагдлууд илэрлээ.



БҮЛЭГ 2: УС РАШААНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАГДСАН БОЛОВЧ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Иргэн, аж ахуйн нэгжүүд ус ашиглуулах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулахгүйгээр ус ашиглаж байна.

2.1 . Усны тухай хуулийн 28.4-д хоногийн хэрэгцээ 50 шоо метр хүртэлх ус ашиглагчийн ус ашиглах дүгнэлтийг аймгийн БОАЖГ гаргаж, ус ашиглах гэрээг сумдын Засаг дарга байгуулах, 50-100 шоо метр ус ашиглах дүгнэлтийг Хар нуур -Ховд голын сав газрын захиргаа гаргаж, гэрээг БОАЖГ байгуулах, хоногын хэрэгцээ 100 шоо метрээс дээш ус ашиглах дүгнэлтийг Монгол Ус ТӨААТҮГ гаргаж, гэрээг Хар нуур -Ховд голын сав газрын захиргаа байгуулан ажиллах хуулийн зохицуулалттай байна.

Аймгийн хэмжээнд ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ус ашиглагч 900 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 2018 онд 17, 2019 онд 28, 2020 онд 21 нийт 66 ус ашиглагч хуулийн этгээд ус ашиглах дүгнэлт гаргуулсан байна.

⁸ Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих;
Аудитын код: ХОА-2021/117/ШТА-НА



- 2018-2020 онд ус ашиглалтын дүгнэлт гаргуулсан дээрх 66 ус ашиглагч хуулийн этгээдүүдээс 31 аж ахуйн нэгж нь зөвшөөрөлгүйгээр,
- Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 1000 орчим энгийн гар худаг байгаагаас 78 нь зөвшөөрөлтэй, бусад нь зөвшөөрөлгүй,

2.2. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулж байна.

Татварын ерөнхий хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчиж 2018-2020 онуудад БОАЖГ нь усны зөвшөөрөл, худгийн зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 11.4 сая, Хар нуур Ховд голын сав газрын захиргаа нь усны зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 2.4 сая нийт 13.8 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогын дансанд төвлөрүүлэхгүйгээр төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Он	Дүгнэлт	Усны зөвшөөрөл	Худгийн зөвшөөрөл	Орлогын дүн	Татварт төвлөрүүлэх	Татварт төвлөрүүлсэн	Нэмэлт дансанд төвлөрүүлсэн
БОАЖГ							
2018 он	2.2	1.8	1.6	5.5	3.4	-	3.4
2019 он	0.8	2.3	2.9	6.0	5.2	-	5.2
2020 он	0.3	0.6	2.2	3.1	2.8	-	2.8
ДҮН	3.2	4.7	6.7	14.6	11.4	-	11.4
Хар нуур сав газрын захиргаа							
2018 он	7.3	0.2	-	7.5	0.2	-	0.2
2019 он	1.4	-	-	1.4	-	-	-
2020 он	3.7	2.2	-	5.9	2.2	-	2.2
ДҮН	12.4	2.4	-	14.7	2.4	-	2.4

Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл хангалтгүй байна.

2.3. Аймгийн хэмжээнд ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулан үзэхэд 2018 онд 39.9 сая төгрөгөөр, 2019 онд 15.5 сая төгрөгөөр тус тус давуулсан, 2020 онд 25.8 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Усны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сумдаар/

Д/д	Сумдын нэр	2018 он		2019 он		2020 он		НИЙТ	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Ховд шууд	114.1	149.2	120.3	128.7	139.1	118.3	373.4	396.1
2	Алтай	1.0	4.7	6.0	0.8	6.4	0.9	13.4	6.4
3	Булган	2.5	2.9	2.5	3.8	2.7	2.7	7.7	9.3
4	Буянт	15.0	12.2	15.0	15.0	16.1	18.0	46.1	45.2
5	Дарви	1.0	2.4	1.0	10.0	1.1	0.3	3.1	12.7
6	Дуут	0.2	1.0	0.2	1.0	0.2	0.9	0.6	2.9
7	Зэрэг	0.5	0.4	0.5	0.8	0.5	0.8	1.5	2.0
8	Манхан	0.3	0.2	0.4	0.4	0.4	0.4	1.1	1.0
9	Дөргөн	1.0	1.0	1.0	1.0	1.1	1.0	3.1	3.0
10	Мянгад	1.5	2.6	1.5	2.4	1.6	2.3	4.6	7.3
11	Мөнххайрхан	0.3	0.2	0.3	0.3	0.3	0.3	0.8	0.8
12	Үенч	0.5	0.3	1.0	3.2	1.1	3.6	2.6	7.2
13	Чандмань	0.3	0.2	0.3	0.3	0.3	0.2	0.8	0.6
14	Эрдэнэбүрэн	2.0	2.1	1.5	0.1	1.6	1.3	5.1	3.5
15	Жаргалант	-	-	5.0	4.4	5.4	0.3	10.4	4.7
16	Мөст	0.4	0.4	0.4	1.0	0.4	1.8	1.2	3.2
17	Цэцэг	0.2	1.2	1.0	1.1	1.1	1.1	2.3	3.4
18	Ховд сум	0.8	0.3	0.8	-	0.8	-	2.3	0.3
НИЙТ ДҮН		141.4	181.3	158.5	174.2	180.0	154.2	479.9	509.7


2.4. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг ус ашиглагч хуулийн этгээдийг бүрэн хамруулж төлөвлөөгүй, түүнчлэн ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавьж ажиллаагүй, хуулиар чөлөөлөгдөх унд, ахуйн хэрэглээний усанд төлбөр ногдуулсан зөрчил байна. Тухайлбал:

- Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх хэсгийг Мо Эн Ко ХХК, Дөргөний УЦС-ийн усны төлбөрийн орлого бүрдүүлж байгаа ба бусад ус ашиглагч аж ахуйн нэгжүүдээс бүрдүүлэх орлогыг оновчтой төлөвлөж бүрдүүлэхгүй,
- 2018-2020 оны хооронд дүгнэлт гаргуулсан 24 ус ашиглагч хуулийн этгээд дүгнэлтээр ногдуулсан төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй,
- Манхан, Зэрэг, Чандмань, Цэцэг, Мөнххайрхан, Дарви, Эрдэнэбүрэн сумууд төсөвт байгууллагуудад унд ахуйн хэрэглээний усанд төлбөр ногдуулж 3.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь хууль, журамд нийцээгүй,
- 14 сум сүүлийн 3 жилийн хугацаанд 100 орчим аж ахуйн нэгжээс усны дүгнэлт, зөвшөөрөлгүй байхад 50.5 сая төгрөгийн усны төлбөрийн орлогыг бүрдүүлсэн,
- Буянт сумын ИТХ нь газар тариалан эрхлэгчдээс усны төлбөр тооцоог мэргэжлийн байгууллагын холбогдох хууль, журамд нийцүүлэн тооцсон дүгнэлтээс зөрүүтэй үнэ тариф тогтоосон,
- Барилга, талх нарийн боов, уурын зуух, халуун ус, жуулчны бааз зэрэг ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд усны төлбөр ногдуулаагүй зэрэг зөрчлүүд байна.

2.5 Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг өмнөх жилүүдийн татварын орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн нь бодит бус байна.

Аудитаар сүүлийн 3 жилийн ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг ус ашиглах дүгнэлттэй харьцуулан үзэхэд 479.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэй, ус ашиглах дүгнэлтээр төлбөл зохих төлбөр 372.9 сая төгрөг, 106.6 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө илүү гүйцэтгэлтэй байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө төлбөрийн эрх зүйг үүсгэдэг мэргэжлийн байгууллагуудын санал, тоон мэдээлэлд үндэслэлгүйгээр, өмнөх жилүүдийн татварын орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа нь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, төсвийн орлогын төлөвлөлт бодитой бус байна.



Ус бохирдуулагч хуулийн этгээдийг бүрэн хамруулж төлбөр ногдуулаагүй байна.

2.6 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ус бохирдуулагч хуулийн этгээдийг бүрэн хамруулж төлбөр ногдуулаагүй, түүнчлэн усыг хууль журмын дагуу ашиглаагүй иргэд, хуулийн этгээдэд хариуцлага тооцож, нөхөн төлбөр ноогдуулах үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоо хангалтгүй байна.

- Усны тухай хуулийг үл хайхран зөвшөөрөлгүйгээр ус ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй авто зам, барилга, барилгын материал үйлдвэрлэгч компаниуд, хуурай замын тээврийн компаниуд, халуун ус, авто угаалга, эсгийний үйлдвэр, сумдад дулаан, цэвэр бохир усны үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулагч, баруун бүсийн төв зах орчимд ус ашиглан үйл ажиллагаа явуулж буй иргэд, бизнес эрхлэгчид зөвшөөрөлгүй ус ашигласнаар байгаа ч холбогдох мэргэжлийн байгууллага нөхөн төлбөр ногдуулаагүй байна.

Усны төлбөр хураамжийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй байна.

2.8 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4.1.5-д ус рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар хуульчилсан.

Гэтэл 17 сумдын ЗДТГ нь усны төлбөрийн орлогын 35 хувийг усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулж хөрөнгө зарцуулсан эсэх нь нотлогдохгүй, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.

Сумдын нэр	2018 он			2019 он			2020 он		
	Өмнөх оны орлогын гүйцэтгэл	35%	Усны нөөц хамгаалах, нөхөн сэргээхэд төлөвлөж зарцуулсан	Өмнөх оны орлогын гүйцэтгэл	35%	Усны нөөц хамгаалах, нөхөн сэргээхэд төлөвлөж зарцуулсан	Өмнөх оны орлогын гүйцэтгэл	35%	Усны нөөц хамгаалах, нөхөн сэргээхэд төлөвлөж зарцуулсан
Д/д									
СУМДЫН ДҮН	27.3	9.6	-	32.1	11.2	-	45.5	15.9	-

Усны орчныг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг бий болгоход анхаарах шаардлагатай байна.

2.9 Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой хэрэглээг бий болгох бодлого зорилтын хүрээнд аймаг сумдын орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, бусад тусгай сангаас 2018-2020 оны хооронд аймаг, сумын хэмжээнд нийт 75 хөтөлбөр арга хэмжээгээр 1461.8 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөж зарцуулжээ.

Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар Ховд сумын Цагаан бураа багт хийгдсэн услалтын суваг, Бичигт, Бугат, Хайрхан багт гаргасан ухаалаг худаг, Дарви сум 2, Мянгад сум 1, Ховд сум 1, Эрдэнэбүрэн сум 1 нийт 8 худгууд, Бугат үзүүрт баригдсан Агропаркын усны барилга байгууламжийн ажил хийгдэж үр өгөөжөө өгч байна.

2.10. Зарим хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлуудын үр дүн хангалтгүй байгаагаас гадна хөтөлбөр арга хэмжээг хэт жижиглэн төлөвлөж зарцуулж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг төдийлөн бий болохгүй байна.



- Мянгад сумын Усны голдирол өөрчлөх, суваг шуудуу сэргээх, шинээр татах ажил: “БЭСА”ХХК-ны гүйцэтгэсэн 100.0 сая төгрөгийн өртөгтэй тус ажилд усны боолтыг сайжруулахаар өгөгдсөн үүргийг хэрэгжүүлээгүйгээс боолт сэтэрсэн,

- Буянт сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажил 69930.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил ажлын даалгаврын дагуу хийгдээгүй, ашиглагч байгууллага хүлээж авахаас татгалзсан,
- Хөрөнгө оруулалтын хэрэгцээ судалгаа байхгүй, үр дүн, үр өгөөжийг тооцоогүй, хэт жижиглэсэн байдлаар төлөвлөж зарцуулсан байна.

БҮЛЭГ 3 ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ ТУЛ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

Аймаг, сумын ИТХ, ЗД, БОАЖГ хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

3.1 Усны тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг, сумдын ИТХ нь ус рашааны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар Сав газрын захиргаа, Засаг даргаас оруулсан төлөвлөгөө хөтөлбөрийг хэлэлцэж батлах, гаргасан шийдвэрийн биелэлтийг хянаж дүгнэх эрхтэй ч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллахгүй байна.

Аудитын төлөвлөлийн явцад аймгийн ИТХ-ын даргад Усны тухай хуулийн хэрэгжилтийн аудит хийгдэж байгаа тухай мэдэгдэл хүргүүлсэн боловч хяналт шалгалттай холбоотой ажил хийгдээгүй, хөтөлбөр батлаагүй, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хянадаггүй байна.

3.2 Усны тухай хуулийн 19.1.2-д “сум, дүүргийн байгаль хамгаалагч нь ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд нь хяналт тавих”, 19.1.4-д “энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх” гэж заасан байна.

Гэвч бодит байдал дээр байгаль хамгаалагч нар мэргэжлийн бус, өөрийн ажил албан тушаалтай холбоотой хууль, дүрэм журмаа судалж ойлгоогүй, төлбөртэй холбоотой асуудал нь татварын байцаагчийн ажил мэтээр хандаж байна.

Мөн Байгалийн нөөц ашигласны тухай хуулийн 23.1-д “сум дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна” гэж заасан байна.

- Энэ нь хууль тогтоомжууд хоорондоо уялдахгүйгээс сумын ЗДТГ, аймгийн БОАЖГ, Татварын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо муутайгаас ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.

3.3 Сумдад байгаль хамгаалагч нар ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалтыг хийгээд татварын байцаагчид хүргүүлж, татварын байцаагч тухайн аж ахуйн нэгж байгууллагын нэр дээр нэхэмжлэх үүсгээд татварын программд шивж оруулж байгаа боловч 3 хоногийн дотор төлбөрөө төлөхгүй бол тухайн нэхэмжлэх автоматаар устдаг байна.

Эндээс үзэхэд Программын энэ үйлдлээс болж төлбөр бүрэн төлөгдөхгүй, төлбөр төлүүлэх үүрэг эзэнгүйдэх нэг шалтгаан болж байна.

3.4 Аймаг, сумдын төрийн байгууллагуудын усны тухай хуулийг хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчний судалгаа хийж үзэхэд:

д/д	Чиг үүргийн байгууллагууд	Орон тоо
1	Аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст мэргэжилтэн	1
2	БОАЖГ -т мэргэжилтэн	3
3	МХГ-ын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч	3
4	Сумдын байгаль хамгаалагч	22
5	Сумдын ЗДТГ-ын байгаль орчны хяналтын байцаагч	17
6	Сумдын газрын даамал	17
7	Тусгай хамгаалалтай газар нутгийн захиргаа	35
8	Сав газрын захиргаа	30
9	Сумдын татварын байцаагч нар	17
НИЙТ ДҮН		145.0

Дээрх хүснэгтээс харахад төрийн байгууллагын усны бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтэц орон тоо хангалттай байгаа боловч салбар хоорондын ажлын уялдаа холбоогүй, бодлого оновчтой бус тус тусдаа ажиллаж хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлэн ажиллахгүй байна.

- Сав газрын захиргаанд ажлын байрны тодорхойлолтод заасан орон тоон дээр усны мэргэжлийн бус хүн ажиллаж байна.
- Ус ашиглагчдыг хуулийн хүрээнд ус ашиглахыг зөвлөсөн, шаардсан албан тоотыг Сав газрын захиргаа болон БОАЖГ –аас хүргүүлж, газар дээр нь шаардлага тавьж ажилладаг ч тухайн байгууллагуудад улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан байхгүйгээс шалтгаалан хуулийн хэрэгжилтийг хангуулах, нөхөн төлбөр ногдуулах, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь засаж залруулах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зэрэг хууль зөрчигчдийн өмнө хүчин мөхөсдөх эрдэл үүсдэг хүндрэл бэрхшээл бий болж байна.

Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй тул үр нөлөөг тооцох боломжгүй байна.

Ус ашиглагчийн ус авах цэг, газар доорх усны цооног, шугамын оролт бүрийг тоолууржуулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд дүгнэлт гаргуулсан 66 ус ашиглагч байгаагаас 2 ус ашиглагч тоолууртай 64 ус ашиглагч тоолуургүйгээр ус ашиглаж байгаа бөгөөд нийт ус ашиглагчийн 96% эзэлж байгаа нь усны тухай хуульд ус ашиглагч ус авах цэг, газар доорх усны цооног шугам хоолой бүрийг тоолууржуулах үүрэгтэй ч ус ашиглагчид үүргээ хэрэгжүүлээгүй, хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагын хяналт сул байгаагаас хэрэглэгчдийг бүрэн тоолууржуулж чадахгүй байна.

Худаг уст цэгийг паспортжуулаагүй байна.

Усны тухай хуульд усны аливаа барилга байгууламж нь паспорттай байхыг заасан бөгөөд аудитаар худаг, уст цэгийн паспортыг тулган үзэхэд аймгийн хэмжээнд нийт 916 худаг байгаагаас 725 худаг паспортгүй байна.

Аймгийн хэмжээнд 2018-2020 онуудад нийт 916 худаг гаргаснаас 66 худагт БОАЖГ-аас зөвшөөрөл олгосон, 850 худагт зөвшөөрөлгүйгээр худаг гаргасан байна.

Аудитаар нийт 513301.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 26055.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд албан шаардлага, 487245.5 сая төгрөгийн 32 зөрчилд 18 зөвлөмж хүргүүлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН ЗӨВЛӨХ НЬ:****Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвгандид**

- ✓ Усны тухай хуулиар хүлээсэн хяналтын чиг үүргийг бүх шатны ИТХ-аар хэлэлцүүлэн ажиллах
- ✓ Усны төлбөр хураамжийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсөв батлах

Аймгийн Засаг дарга Б.Дүгэржавт

- ✓ Аймгийн хэмжээний усны нөөцийн хэмжээг тогтоох ажлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

Аймгийн БОАЖГ-ын дарга Л.Батбаярт

- ✓ Аймгийн усны мэдээллийн санг усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмын дагуу мэдээллийг бүрдүүлж сав газрын захиргааг мэдээллээр хангах.
- ✓ Усны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчлийг арилгах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- ✓ Усны тоо бүртгэлийг чанартай зохион байгуулж, ус рашааны тоо бүртгэлийн дүнэ нэгтгэн цахим программ хангамжийн ашиглалтыг сайжруулах
- ✓ Усны дүгнэлт гаргасан, зөвшөөрөл олгосон, худгийн зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлж ажиллах

Сав газрын захиргааны дарга Р.Энхсүрэн-д-99439837

- ✓ Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг үнэн бодитой тодорхойлох.
- ✓ Ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжийн зөрчлийг арилгуулах.
- ✓ Усны дүгнэлт гаргасан, зөвшөөрөл олгосон тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлэх
- ✓ Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих

Сумдын ИТХ-ын дарга нарт

- ✓ Сумын Засаг дарга нарын саналыг үндэслэн сумдын ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн зааг тогтоох, тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг ханган ажиллах

Жаргалант сумын Засаг даргад

- ✓ Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн Цамбагараг баг ойн бүсэд олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох 2020 оны 5 дугаар сарын 21-ны өдрийн 21-04/047/61 тоот дүгнэлтийг хэрэгжүүлэн зөрчлийг арилгаж ажиллах

Сумдын Засаг дарга нарт:

- ✓ Усны мэдээллийн санг аймгийн мэдээллийн сантай тулган баталгаажуулан үнэн зөв мэдээлэх
- ✓ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын,эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах.
- ✓ Ус ашиглалтыг хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэн, хяналтыг сайжруулах.
- ✓ Ус рашаан ашигласны төлбөрийг хууль эрх зүйн хүрээнд нийцүүлэн төлөвлөх, ногдуулах, төлүүлэх
- ✓ Уст цэг бүрийг паспортжуулах, зөвшөөрөлгүй худаг гаргах, тоолуургүй ус ашиглах зөрчлийг таслан зогсоох.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж 2021 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

**АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР**

**Л.ГАЛБАДРАХ
Д.БАЛЖИННЯМ
Б.ДОЛЖИНЖАВ**

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

Усны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайланд санал авахаар ИТХ, Засаг дарга, БОАЖГ, Хар нуур Ховд голын сав газрын захиргаанд албан тоот хүргүүлсэн.

Д/д	Холбогдох байгууллага	Ирүүлсэн санал	Тайланд тусгасан
1	БОАЖГ	Ирүүлээгүй	Албан тоотоор санал ирүүлээгүй
2	Хар нуур Ховд голын сав газрын захиргаанд	Ирүүлсэн	Санал давхацсан
3	Аймгийн ИТХ	Ирүүлсэн	Тайланд тусгах боломжгүй
4	Аймгийн Засаг дарга	Ирүүлсэн	Тайланд тусгах боломжгүй

Аудитын явцад аймгийн ИТХ-ын 2020 оны 11/05 дугаар тогтоолыг хүчингүй болгох албан шаардлага бүхий тайлангийн төсөл хүргүүлж, үүнд ИТХ, Засаг даргаас хариу тайлбар ирүүлэхдээ Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 15 өдрийн 11/05 тогтоол нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хууль зүй дотоод хэргийн яаманд хянуулж, холбогдох өөрчлөлтийг баталгаажуулсан тул албан шаардлагыг биелүүлэх боломжгүй байна гэжээ.

Амалсан Бүрэлдэгч 17.

МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

84140 Ховд, Ховд аймаг
Утас/Факс (+976) 70433601
E-mail: Khovd@govern.mn

2021.09.27 № *1/1399*

танай *2021.09.25*-ны № *2/248* -т

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.САНДАГСҮРЭН ТАНАА

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/05 тогтоолыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж хянуулсан бөгөөд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь эрх зүйн актыг бүртгэхдээ хууль зүйд нийцсэн эсэх талаарх судалгааг хийдэг.

Иймд тухайн актыг хууль зүйд нийцсэн гэж үзэж байна.

ЗАСАГ ДАРГИЙН
ОРЛОГЧ *Т.ЖАРГАЛСАЙХАН*

А.Нунгуун
Засаг дарга

Б.Сандагсүрэн
2021.09.27

02.1702
2021 А/5 КН



Атлас Барилгын 18

ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ

84140 Ховд, Ховд аймаг
Утас/Факс: 7043-2105
E-mail: khovd.khural.gov@gmail.com

2021.09.29 № 2/252

танай 2021.09.13 ны № 199 -Т

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА

Жаргалант сумын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийг тогтоосон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/05 тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу холбогдох хуульд заасан шаардлагыг хангасан эсэх асуудлаар Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн болно.

Иймд тухайн хэм хэмжээний актыг хууль зөрчсөн, хүчингүй болгох тухай албан шаардлагаа дахин хянаж үзнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.САНДАГСҮРЭН
0000453

D-2021-A5

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар :

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Саналд өгөх тайлбар	
Тайлбар 1.	Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн яамны 2021.10.07-ны өдрийн 3/4309 дугаар албан тоотоор Ховд аймгийн ИТХ-аас Захиргааны ерөнхий хуулийн 66 зүйлийн 66.1.1-д ".....нөлөөллийн шинжилгээний танилцуулга.." гэж заасан бүрдлийн хүрээнд ирүүлсэн нөлөөллийн шинжилгээний танилцуулгын хувийг ирүүлсэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалын хавсралт 1.5 "Захиргааны хэм хэмжээний актын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийх ажлыг шийдвэр гаргах эрх бүхий этгээд удирдан зохион байгуулах бөгөөд нөлөөллийн шинжилгээний үнэн зөвийг хариуцна" гэсний дагуу Аймгийн ЗДТГ-ын хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н. Ганзоригийн хийсэн нөлөөллийн шинжилгээг үндэслэсэн байгаа тул тайланд тусгах боломжгүй.
Тайлбар 2.	Захиргааны ерөнхий хууль 61.1."Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх ажиллагааг тухайн актыг гаргах эрх бүхий захиргааны байгууллага зохион байгуулна", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалын хавсралт 1.5 "Захиргааны хэм хэмжээний актын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийх ажлыг шийдвэр гаргах эрх бүхий этгээд удирдан зохион байгуулах бөгөөд нөлөөллийн шинжилгээний үнэн зөвийг хариуцна". Аймгийн ЗДТГ-ын хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н. Ганзоригийн хийсэн нөлөөллийн шинжилгээ нь Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно", Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын 3.14-д "Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх болон урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашиглавал эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан уст үеэс ус авч ашиглавал 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно" 3.9-д "Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Захиргааны ерөнхий хуулийн 62.1-д "Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна", 62.2.-д "Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ", 62.3.4-д "тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд хэлэлцүүлэг хийж болно", 29.1. -д "Захиргааны байгууллагаас захиргааны шийдвэрийн хувийн хэргийг хөтлөх бөгөөд уг хувийн хэрэгт шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал, холбогдох баримт, сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг бүрдүүлэн, архивт хадгална". Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалын хавсралт 1.5-д "Захиргааны хэм хэмжээний актын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийх ажлыг шийдвэр гаргах эрх бүхий этгээд удирдан зохион байгуулах бөгөөд нөлөөллийн шинжилгээний үнэн зөвийг хариуцна", 2.4-д. "Нөлөөллийн шинжилгээгээр тухайн шийдвэрийг гаргах зайлшгүй шаардлагатай нь тогтоогдсон тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу санал авах ба мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, 62.3, 62.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулна." гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байгаа тул тайланд тусгах боломжгүй байна.

Тайлбар 3.	Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020.12.03 өдрийн 01/8385 дугаар албан тоотоор Ховд аймгийн ИТХ-ын даргад Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга хот, байгуулалтын сайдын 2015 оны А/230/127 дугаар хамтарсан журмын 3.14 дэх заалтыг мөрдлөг болгож 2020 оны 11 дүгээр хуралдаанаар гаргасан 8/11 тоот тогтоолыг хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэх талаар албан тоотоор ирүүлсэн мэргэжлийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрч байгаа тул тайланд тусгах боломжгүй байна.
Тайлбар 4.	Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2020.09.15 өдрийн 01/60 дугаар албан тоотоор ИТХ-ын тогтоол нь Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга хот, байгуулалтын сайдын 2015 оны А/230/127 дугаар хамтарсан журмын 2.5, 2.6, 2.9 дэх хэсэгтэй зөрчилдөж Ховд хотын хүн амыг баталгаат ундны усаар хангахад дээрх журмын холбогдох зүйл заалтуудыг мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг Ховд аймгийн ИТХ, Хар нуур Ховд голын захиргаанд хүргүүлсэн мэргэжлийн байгууллагын чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил дутагдал илэрч байгаа тул тайланд тусгах боломжгүй байна.

Тайлбар 1. Холбоотой баримт:


**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2021. 10. 07 № 3/4309

танай 2021. 09. 29 -ны № 240 -Т

Хариу хүргүүлэх тухай

Танай 2021 оны 240 тоот албан бичигтэй танилцаад Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1-д ".....нөлөөллийн шинжилгээний танилцуулга .." гэж заасан бүрдлийн хүрээнд ирүүлсэн нөлөөллийн шинжилгээний танилцуулгын хувийг хүргүүлж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэх явцад хийгдсэн нөлөөллийн шинжилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухайн актыг гаргах эрх хуулиар тусгайлан олгогдсон байгууллагад хандан авах боломжтой.

Хавсралт: .6. хуудастай

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.БААСАНДОРЖ

Ф. Батмунхуу

*Монгол улс,
Т. Төгрөг*

2021.10.18.

A4 Файл.2021

151614114

Тайлбар 2. Холбоотой баримт:

2

**ХОВД АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН БАЙГАЛИЙН
ХИЛИЙГ ЗУРАГЛАСАН АЖЛЫГ ТАЛУУДАД ТАНИЛЦУУЛАХ, ХУУЛЬ ЭРХЗҮЙН
ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН НӨЛӨӨЛЛИЙН
ШИНЖИЛГЭЭ**

НЭГ. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, журам гаргах үндэслэл, шаардлага, зорилт

Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг тодорхой заасан байдаг.

11.1.2. Усны нөөцийг хомсдох бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, Ус усан орчинг нөхөн сэргээх, усны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сав газрын захиргаа, Засаг даргаас оруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийг хэлэлцүүлж батлах

11.1.4. Энэ хуулийн 22.1-22.4-т заасны дагуу Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг хот, суурины ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтоох

Усны тухай хуулинд "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230/127 тоот тушаалаар зохицуулагдаж байгаа болно.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны "Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай" 8/11 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулахаар Ховд аймагт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, төлөөлөгчдийн төлөөлөл, Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Хүнс хөдөө аж ахуй газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Шим-Ус Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, иргэдийн төлөөллүүдээс бүрдсэн нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

ХОЁР. Захиргааны хэм хэмжээний актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү тогтоолд өөрчлөлт оруулах ажилд Аймаг сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс хөдөө, аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар оролцож аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчид эцсийн шийдвэрийг гаргана.

Жаргалант сумын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн 6 худгийн эрүүл ахуйн бүсийн талбайн хэмжээ, хилийг газар зүйн мэдээллийн системийн ARCGIS программ ашиглан 300 метр болгон өөрчлөн зураглаж эргэлтийн цэг, координатыг тодорхойлон Аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Хүнс хөдөө аж ахуй, Байгаль орчны байнгын хороо, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн хуралдаанд шат дараатайгаар танилцуулсан.

ГУРАВ. Захиргааны хэм хэмжээ акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлэг байгаа эсэх

Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоосноор Жаргалант сумын айл өрх, иргэдийн амарч зугаалах, зусланд гарах аятай тохитой нөхцлийг хангах үүднээс зураглалаас төв стадионы ар талын улиаснаас, Улаан богочийн рашаан хүртэлх газрын координатыг хасаж Усны сан бүхий газарт зусланд гарах айлуудыг дэглэмийг журмаар зохицуулж байна.

ДӨРӨВ: Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Журам нь Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

ТАВ. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх

Усны тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хууль Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яам, Барилга хот

байгуулалтын яамны сайдын хамтарсан 2015 оны 230/127 тоот тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны "Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай" 8/11 дүгээр тогтоолоор зохицуулагдаж байна.

ЗУРГАА. Захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо

Тогтоолыг хэрэгжүүлэхэд техник, эдийн засгийн ямар нэгэн хүчин зүйл шууд шаардагдахгүй бөгөөд харин хяналт шалгалт, зохион байгуулалт, зохицуулах эрх хэмжээ чухал үүрэг гүйцэтгэнэ.

Тогтоолд орсон өөрчлөлтийг Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар хүний нөөц, материаллаг бааздаа тулгуурлан хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Нэмэлт зардал, хүний нөөцийн эрэлт шаардагдахгүй болно.

Цаашид сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын даамлуудыг оролцуулсан сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж хяналт тавьж ажиллана.

ТАНИЛЦСАН:

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ОРЛОГЧ




Т.ЖАРГАЛСАЙХАН

НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН

ХЭЛТСИЙН ДАРГА



Н.ГАНЗОРИГ

Тайлбар 3. Холбогдох ажлын баримт

3



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2020.12.03 № 01/8385

танай _____-ны № _____-т


Асуудал шийдвэрлэх тухай

Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр хуралдаанаар Ховд аймгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хязгаарлалтын бүсийг тогтоосон тогтоол холбогдох хууль, журмыг зөрчсөн тухай мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаас тус яаманд ирүүлээд байна.

Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2018 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 8/11 тоот тогтоолоор Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг баталсан байдаг.

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг баталсан. Энэхүү журмын 3.14 дэх хэсэгт төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх болон урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашиглавал эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд хязгаарлалтын бүсийг тогтооно гэж заасан байдаг. Ховд аймгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэр нь урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашигладаг. Иймд дээрх 2020 оны 11 дүгээр хуралдаанаар гаргасан тогтоолыг хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ үү.

Хувийг Харнуур-Ховд голын сав газрын захиргааны дарга Р.Энхсүрэнд.



Д.САРАНГЭРЭЛ

Тайлбар 4. Холбогдох ажлын баримт

474

АТЛАН БАРИМТ № 10.

**ХАР НУУР ХОВД ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНД**

УСНЫ ГАЗАР

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингүнжавын гудамж, Утас/Факс: (976-51) 26 44 47,
И-мэйл: contact@mwa.mn

2020.09.15 № 04/60

Танай _____-ны № _____-т

Чиглэл өгөх тухай

Танай ирүүлсэн албан тоот, иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа.

Уг тогтоолын төсөл нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан А-230/127 тоот тушаал, Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 2.5, 2.6, 2.9 дэх хэсэгтэй зөрчилдөж байна.

Ховд аймгийн Ховд хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөц тогтоох ажлыг 2007 онд хийсэн бөгөөд энэ ажлын хүрээнд хүн амыг төвлөрүүлэн суурьшуулах, газрын хөрсийг ухаж сэндийлэх, гадаргуугийн хэлбэр дүрсийг эвдэж зөрчлөх, аж ахуйн болон инженерийн шийдэлтэй техноген үйл ажиллагаа явуулахыг хориглох талаар дүгнэлт өгсөн байна.

Иймд Ховд хотын хүн амыг баталгаат ундны усаар хангахад дээрх журмын холбогдох зүйл заалтуудыг мөрдөж хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралтаар 2007 онд хийсэн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоосон үр дүнгийн тайлангаас холбогдох дүгнэлтийг хүргүүллээ.

Хавсралт 7 хуудастай.

Хувийг Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд.

ДАРГА  Ш.МЯГМАР

2020 onii bichig

10.200030



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**ХАР НУУР-ХОВД ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

84149 Ховд аймаг, Жаргалант сум, 8 дугаар баг,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байр,
Утас/факс: (976) 7043 2228, Вэбсайт: www.khovd-gol.mn

2021.08.08 № 2021
танай _____-ны № _____-т

АУДИТЫН ГАЗАРТ

Танайхаас хийгдсэн Усны тухай хуулийн
хэрэгжилт нийцлийн аудитад нэмэлтээр саналаа гаргаж
хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.



**УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

2021.08.02

Жаргалант сум

**1.УС РАШААНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭРЭГЖИЛТ:**

1. Ус ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх, төсөвт төвлөрүүлэх чиглэлээр аймгийн ЗДТГазраас нэгдсэн бодлого дутмаг, аймаг орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад усны төлбөр тооцох хөшүүргийг бий болгодоггүй, ус ашиглаж бүтээн байгуулалт хийж буй бүтээн байгуулалтын ажлууд хууль бусаар ус ашиглаж байна.
2. Ховд аймагт ус ашигласны төлбөрийн орлого, бүрдүүлэлтийн дийлэнх төсвийг Дөргөний усан цахилгаан станц, Шим ус ОНӨААТҮГазар, Мон Эн ко ХХКомпаниудаас бүрдүүлж байгаа нь сав газар бүрэн эрхийнхээ хүрээнд зөвшөөрөл олгож, ногдуулалтын хувь хэмжээг хуулийн хүрээнд тооцосны дагуу оруулж байгаа бөгөөд Усны тухай хуулийн 28,4. 28.6-д заасны дагуу 50м³-аас доош ус ашиглагч аж ахуйн нэгжид БОАЖГазар ногдуулалт хийх ёстой бөгөөд 50м³-100м³ ус ашиглагчдад Сав газрын захиргаа ногдуулалт хийж дүгнэлт гаргах хуулийн зохицуулалттай. Ховд аймгийн хэмжээнд 50-100 шоометр, 100-аас дээш шоометр ус ашиглагч аж ахуйн нэгж харьцангуй цөөн. Ус ашиглагч аж ахуйн нэгжийн 90-с дээш хувь бага ус ашиглагч буюу Байгаль орчин аялал жуулчлалын газарт хамаарагдахаар байгаа юм. Гэтэл дүгнэлт гаргаж эрх зүйн орчинг бүрдүүлээгүйгээс шалтгаалан төлбөрийн орлогын хувь хэмжээ хэдхэн аж ахуйн нэгжид буюу сав газрын захиргааны гаргасан дүгнэлт, зөвшөөрлийн хүрээнд төвлөрч байна.
3. Ус ашигласны төлбөрийн орлогыг төсөвт оруулах, төвлөрүүлэлтийн гүйцэтгэлд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар Сумын Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна гэсэн заалт хэрэгждэггүй. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хуульд сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч болон байгаль хамгаалагч нар төлөлтөд хяналт тавих ёстой ч төвлөрүүлэлт хангалтгүйгээс үүдэн төлөвлөгөө тасрах эрсдлийг үүсгэдэг.
4. Аймгийн ЗДТГазраас тухайн жилд хэдэн төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө зохиохдоо төлбөрийн эрх зүйг үүсгэдэг мэргэжлийн байгууллагуудаас санал авдаггүй, хэдэн төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө зохиосон нь тодорхойгүй байдгаас төлөвлөлт буруу явагддаг.
5. Сумдууд ус ашигласны төлбөрийн орлогыг дүгнэлтэд үндэслэхгүйгээр тухайн суманд ус ашиглаж үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдэд шууд ногдуулалт хийдэг. Тухайн аж ахуйн нэгжид хуулийн хэрэгжилт хангуулах чиглэлээр шаардлагыг хууль ёсны дагуу тавьдаггүй, төлбөрийг ногдуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх БОАЖГазар болон Сав газрын захиргааг мэдээллээр хангаагүйгээс хуулийн хүрээнд ус ашигласны төлбөр төвлөрүүлэхгүй байна.
6. Ус ашиглагчдыг хуулийн хүрээнд ус ашиглахыг зөвлөсөн, шаардсан албан тоотыг Сав газрын захиргаа болон БОАЖГазраас жил бүр хүргүүлж, газар дээр нь шаардлага тавьж ажилладаг ч тухайн байгууллагуудад улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан байхгүйгээс шалтгаалан хэрэгжилтийг хангуулах, нөхөн төлбөр ногдуулалт хийж чадахгүй зэрэг хууль зөрчигчдийн өмнө хүчин мөхөсдөх шалтгаан болж байна.

7. Сав газрын захиргаа нь ус ашигласны төлбөрийг ноогдуулах эрхзүйн орчинг бүрдүүлж Татвары хэлтэс төлбөр ноогдуулалт хийж төсөвт төлбөрийг төвлөрүүлж ажиллах хуулийн зохицуулалттай.

8.

2.УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР УС, УСАН ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗОХИОН БАЙГУУЛААЛАЛТ:

1. Засгийн газрын 43 дугаар тогтоол байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журманд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна гэж заадаг бөгөөд дараах ажлыг хуулийн хүрээнд хийж гүйцэтгэх ёстой байдаг ч төсөвт тусгаж өгдөггүйгээс үүдэн хийж чаддаггүй.

1. Усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийх /Төсөвт тусгаж өгдөггүй/
2. Усны үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг болон хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэх, тоолууржуулах, унд-ахуйн ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнгэгжүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, хаягдал ус зайлуулах цэгийг сайжруулах;
3. Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;
4. Усны сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
5. Усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас, борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, рашаан, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шанд, баянбүрдийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд тус тус зарцуулах ажлуудыг төлөвлөн хийх ёстой байтал аймгийн Засаг даргаас тухайн жилд хийх арга хэмжээг төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагуудаас санал авдаггүй, төсөвлөсөн зардал нь ус усан орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулагддаггүй.

Ховд аймгийн жил бүрийн уснаас орох төсвийн 90 орчим хувийг Сав газрын захиргаанаас үндэслэлийг боловсруулан төвлөрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн ч аймаг орон нутгийн зүгээс ямар ч санхүүгийн хувьд дэмжлэггүйгээр ажилладаг. Рашаан, булгийн эх тохижуулах, голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэм мөрдүүлэх ач холбогдлыг ард иргэдэд таниулан сурталчлах нөлөөллийн аян, самбар, тэмдэгжүүлэлтийг хийж ирсэн.

3. УС АШИГЛАЛТ, ХЭРЭГЛЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ:

Аймаг орон нутагт шинээр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд, хүн амын болон бэлчээрийн усан хангамж сайжруулахаар аймаг орон нутгийн төсвөөр хийгдэх шинээр гаргах худаг,

бүтээн байгуулалтын ажлуудад тавих хяналтын болон хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагаас оруулдаггүй.

4. УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯЗГААРЛАЛТЫН БҮСЭД ОЛГОСОН ГАЗАР ОЛГОЛТЫН АСУУДАЛ:

Шим ус ОНӨААТҮГазар нь 2012 оноос 2020 хүртэл эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэмийг дотоодын цэргийн өндөржүүлсэн бэлэн байдал, хамгаалалт дор үйл ажиллагаа явуулж ажиллаж байсан ч аймаг орон нутгийн шийдвэрээр газар олголтод тухайн бүс орсон нь хамгаалалтын дэглэм хангалттай түвшинд мөрдөгдөөгүйг илтгэж байна. Хар нуур Ховд голын сав газрын захиргаа 8/11 тогтоолын хэрэгжилтийг хангах, уг хууль зөрчиж газар олгосон байдлыг Хууль зүйн яаманд албан бичгээр хандсан бөгөөд БОАЖСайд Б.Сарангэрэлд шийдвэрлүүлэхээр уг албан тоотыг шилжүүлсэн бөгөөд газар олголтыг хууль зөрчиж байгааг сануулан хүчингүй болгох тухай хариу албан бичгийг Аймгийн иргэдийн хуралд хүргүүлсэн байдаг.

5.УСНЫ ЧАНАР, ЭКОЛОГИЙН АСУУДАЛ:

Ховд аймгийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадал байгальд хаях стандартад хүрдэггүйгээс үүдэн сар бүр цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усанд шинжилгээ хийлгэсэн бөгөөд цэвэрлэгээний түвшин хангалтгүй хэмжээнд байна.

1 сар: 49%	7сар: 35%
2сар: 51%	8сар: 24%
3сар: 53%	9 сар: 27,5%
4 сар: 54%	10 сар:15%
5сар: 28%	11сар: 13,2%
6 сар: 30%	12 сар: 33,9%

Сав газрын захиргааны зүгээс цэвэрлэх байгууламжийн аваарын хоолойноос бүрэн цэвэрлэгдээгүй бохир ус Буянт голтой нийлж хүн амын эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа асуудлыг Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, аймгийн Цагдаагийн газрын Экологийн албанд тус тус хандан шалгалт хийлгэн хэрэг үүсгэсэн боловч Ховд аймгийн Прокурорын газарт очоод зөрчлийн чанартай, хүний амь насанд үүсгэсэн ноцтой зөрчил байхгүй, эрүүгийн хэрэг үүсгэхээргүй байгаа гэсэн үндэслэлээр буцаагдсан. Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Х.Мөнхжаргалд Зөрчлийн хуулиар арга хэмжээ авахыг зөвлөсөн боловч өнөөдрийг хүртэл арга хэмжээ авагдаагүй байна. Сав газрын захиргаанаас цэвэрлэх байгууламжийн аваарын хоолойноос гарч буй цэвэрлэгээний стандарт хангаагүй бохир ус голруу цутгаж байгаад удаа дараа албан тоот хүргүүлэх, холбогдох мэргэжилтнүүд Шим ус ОНӨААТҮГазрын албан тушаалтнуудад шаардлага тавьж ажилласан ч дорвитой арга хэмжээ аваагүй байдаг.

Ховд аймаг усны аюулгүй байдлын төлөвлөгөө батлуулах шаардлагатай ч холбогдох албан байгууллагууд оролцоо хангалтгүй өнөөдрийг хүрсэн.

2.6 +Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг Аймгийн Мэргэжлийн хяналтын байцаагч ноогдуулна.

2.9 +Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зэрэг суманд услалтын систем баригдаж байна.

1.4 +Манхан сумын цэвэр усны станцын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газарт байгуулаагүй гудамжинд баригдсан.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН:

Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа нь удирдах ажилтан 1, гүйцэтгэх албан тушаалтан 7, жолооч 1, албан хаагчид ажиллаж байгаа болно.

ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

/Мянган төгрөгөөр/

№	Аудитын чиглэл /асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн мян. төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл
А	2	3	4.0	5
1	Усны мэдээллийн санг журмын дагуу бүрдүүлж, аймгийн хэмжээний усны нөөцийг үнэн зөв тогтоосон эсэх.	Аймаг орон нутгийн удирдлага болон мэргэжлийн байгууллагуудад ундны усны нөөцийг шинэчлэн тогтоох хэрэгцээ шаардлагын судалгаа, тоон мэдээлэл, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө зэрэг байхгүйгээс аймгийн хэмжээний усны нөөцийг тогтоогүй байна.	-	Зөвлөмж
2	Усны нөөцийг хамгаалах, усан орчныг нөхөн сэргээх арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэх	Жаргалант сумын Буянт багийн 19 дүгээр гудамжинд 14 га газарт 350 өрхөд гэр бүлийн хэрэгцээнд зориулан шинээр газар эзэмшүүлэхээр шийдвэр гаргаж, ундны усны эх үүсвэрт суурьшлын бүс бий болгосон нь ард иргэдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа зөрчил дутагдал,		Албан шаардлага
3		Түүвэрт хамрагдсан Манхан, Зэрэг, Цэцэг, Чандмань, Жаргалант сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нар нь Усны тухай хуульд заасан усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн зааг тогтоох, тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, хуулийн хэрэгжилт сум орон нутагт хангалтгүй байна.		Зөвлөмж

4		Цамбагарав баг ойн бүсэд- 37 иргэн, аж ахуйн нэгжид 29.09 га талбайд, Буянт баг ойн бүсэд, Их голын ард гүүрнээс дээш 78 иргэн, аж ахуйн нэгжид 255.7 га газарт ойжуулалт, мод үржүүлэг, жимс жимсгэнэ тарих, нөхөн сэргээх зориулалтаар газар эзэмшүүлж байна. Эдгээрээс газар эзэмшигч нараас газрыг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй, газар эзэмших эрх нь хүчингүй болсон, зөвшөөрөлгүй газар торлож авсан, мод тайрсан, үйл ажиллагаа явуулаагүй, айл өрхүүд өөрсдийн талбайдаа зориулан дур мэдэн хоолой гарган чулуу болон цементээр доторлож усан сан үүсгэн, Цагдаагийн газар, Ховд Агропарк болон зарим нэр бүхий иргэд нар зөвшөөрөлгүй энгийн гар худаг гаргасан зөрчлүүд байна.		Зөвлөмж
5	Усны тоо бүртгэлийг зохион байгуулж улсын усны мэдээллийн санд оруулсан эсэх.	Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулна гэж заасан боловч 2018 онд усны тооллого хийгдэж, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.	-	Зөвлөмж
6		Орн ү д оооөөеі ääãó õîîëëî ãñã ç°ãðîí õîîëîãññîí, õñðàé áíëîí øëäýñýí õîî ð°äëëõî°ð ä¿ì ýáýý ãäðããää îððëæ äàéãää í ù ó÷ëä äóðããäëäé äàéí à. Õîî ýáýýí ä ä¿ì øëî æëëýý ðëëð, øëäýñýí õñî ù øàëöããäí ù ä õîäîðîëëîð, øëäýýäé õñî ù í°ð, òãðëî ä äàðëî æäæäð, ò¿¿ ä ¿äýñýí äãäð äðãä õýí æýýä õîäîðîëëîä¿é äàéãää í ù õñî ù õîîëëîã ðëëðëëí à÷ õîëáíãññî, çàððóóëññîí ò¿¿æëí áíëîí ò¿ì ëëí°ðëëí ¿ð àð æëëäáóððóóæäàéí à.	-	Зөвлөмж
7		Хуульд мэдээллийн санг үүсгэх, хариуцах байгууллага болон өгөгдлийг бүрдүүлэх давтамжийг тодорхой зааж өгсөн боловч усны нөөц, ашиглалтын нэгдсэн мэдээллийн сан хангалттай хэмжээнд бүрдэж чадаагүй, нэгдсэн мэдээллийн олдоц хангалтгүй байна.		Зөвлөмж
8	Хүн амын унд ахуйн хэрэглээний усны чанар иргэдийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх.	Ховд аймгийн ард иргэдийн байнга очиж ундны усандаа хэрэглэж байгаа Богочийн рашаанаас дээж авч лабораторийн шинжилгээ хийхэд E-coli болон халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бактери илэрсэн ч иргэд рашаанаас өдөр тутам хэрэглэж байна.		Зөвлөмж

9		Ард иргэд зөвшөөрөлгүй, нүхэн жорлонгийн түвшний хэмжээнд гар аргаар ухсан, шинжилгээгээр шаардлага хангахгүй худгаас хөрсний усыг унд ахуйдаа хэрэглэж байгаа нь өвчин үүсэх, халдварт өвчин тархах эрсдэл үүсэхээр байна.		Зөвлөмж
10		Гэр хорооллын ус түгээх байрны орчин бохирдолтой эрүүл орчны дэглэм алдагдсан, хашиж хамгаалсан хайс эвдэрсэн зөрчил дутагдал илэрлээ.		Зөвлөмж
11		2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ундны усны хангамжийг сайжруулах, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Алтай, Дөргөн, Дуут, Үенч сумдад хэрэгжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын үр өгөөж, ашиглалт шаардлага хангахгүй байна.	400,000.0	Зөвлөмж
12	Аймгийн БОАЖГ нь усны тухай хуулийн 18.1.3.-д “усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчныг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих” гэж хуульчилсан байна.	Ховд хотын техникийн цэвэрлэх байгууламж ачааллаа дийлэхгүй, аваарын хоолойноос бүрэн цэвэрлэгдээгүй бохир ус Буянт гол руу цутгаж хүн амын эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа,		Зөвлөмж
13		Зэрэг сумын цэвэрлэх байгууламж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан, бохир усыг байгалийн аргаар хөрсөнд шингээдэг нягтруулсан шороон байгууламж бөгөөд 2018 оноос энэ байгууламжийн хүчин чадал нь хүрэлцэхгүй болсон, өвлийн улиралд бохир нь хальж орчныг бохирдуулж байна.		Зөвлөмж
14		Аймгийн сумууд төвлөрсөн халаалт, инженерийн хийцтэй шугам сүлжээнд холбогдож байгаатай холбоотой цэвэрлэх байгууламж байхгүй дур мэдэн цооног гаргаж бохир ус хуримтлуулж байгаа зөрчил дутагдлууд илэрлээ.		Зөвлөмж
15		Манхан сум 0.4 сая, Зэрэг сум 0.5 сая, Чандмань сум 0.3 сая төгрөгийн ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас, гүйцэтгэлээр Сургууль, Цэцэрлэг, ЭТМ, Соёлын төв гэсэн төсөвт байгууллагуудаас төлбөрийн орлогоо бүрдүүлж, банкууд, шатахуун түгээх станц, барилга, талх, чихэр, нарийн боов, уухын зуух, халуун ус, жуулчны бааз зэрэг ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд усны төлбөрийн ногдуулалт хангалтгүй байна.		Зөвлөмж

16		Цэцэг суманд хуурай замын тээврийн үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжүүд зөвшөөрөлгүй, ус ашиглах дүгнэлтгүйгээр гүний худаг гаргасан,		Зөвлөмж
17	2.1. Ус ашиглуулах дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах үйл явц хуулийн дагуу хэрэгжиж байгаа эсэх.	2018-2020 онд ус ашиглалтын дүгнэлт гаргуулсан дээрх 66 ус ашиглагч хуулийн этгээдүүдээс 2018 онд 15, 2019 онд 13, 2020 онд 7, нийт 35 хуулийн этгээд ус ашиглах зөвшөөрөл авч, 31 хуулийн этгээд зөвшөөрөлгүй ус ашиглаж байна. Усны тухай хуулийг үл хайхран зөвшөөрөлгүйгээр ус ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй авто зам, барилга, барилгын материал үйлдвэрлэгч компаниуд, хуурай замын тээврийн компаниуд, халуун ус, авто угаалга, эсгийний үйлдвэр, сумдад дулаан, цэвэр бохир усны үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулагч, баруун бүсийн төв зах орчимд ус ашиглан үйл ажиллагаа явуулж буй иргэд, бизнес эрхлэгчид зөвшөөрөлгүй ус ашигласаар байгаа ч холбогдох мэргэжлийн байгууллага нөхөн төлбөр ногдуулаагүй байна.		Албан шаардлага
18		Буянт сумын ИТХ газар тариалан эрхлэгчдээс усны төлбөр тооцоог мэргэжлийн байгууллагын холбогдох хууль, журамд нийцүүлэн тооцсон дүгнэлтээс зөрүүтэй үнэ тариф тогтоож байна.		Зөвлөмж
19		Татварын ерөнхий хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчиж 2018-2020 онуудад БОАЖГ нь усны зөвшөөрөл, худгийн зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 11.4 сая, Хар нуур Ховд голын сав газрын захиргаа нь усны зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 2.4 сая нийт 13.8 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогын дансанд төвлөрүүлэхгүй, төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.	13,800.0	албан шаардлага
20	2.3. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж ногдуулж, төвлөрүүлсэн эсэх.	2018-2020 оны хугацаанд дүгнэлт гаргуулсан ус ашиглагч хуулийн этгээдээс 24 аж ахуйн нэгж дүгнэлтээр ногдуулсан төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	12,255.7	Албан шаардлага
21		Сумдын байгаль орчны байцаагчид ус ашиглагч иргэн, хуулийн этгээдээр усны дүгнэлт гаргуулахгүйгээр төлбөр ногдуулдаг үйлдэл ихээхэн байна. Тухайлбал сүүлийн 3 жилийн хугацаанд 14 сумд 100 орчим аж ахуйн нэгжээс дүгнэлт, зөвшөөрөлгүй байхад 50.5 сая төгрөгийн усны төлбөрийн орлогыг бүрдүүлсэн байна.	50,544.8	Зөвлөмж

22		Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 1000 орчим худаг байгаагаас 66 худаг зөвшөөрөлтэй, бусад нь зөвшөөрөлгүй гаргасан худаг бүртгэлтэй байна.		зөвлөмж
23		Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх хэсгийг Мо Эн Ко ХХК, Дөргөний УЦС-ийн усны төлбөрийн орлого бүрдүүлж байгаа ба бусад ус ашиглагч аж ахуйн нэгжүүдээс бүрдүүлэх орлогыг оновчтой төлөвлөж бүрдүүлэхгүй байна.		Зөвлөмж
24		Манхан, Зэрэг, Чандмань, Цэцэг, Мөнххайрхан, Дарви, Эрдэнэбүрэн сумдууд төсөвт байгууллагуудад унд ахуйн хэрэглээний усанд төлбөр ногдуулж 3.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь хууль, журамд нийцээгүй,		Зөвлөмж
25		14 сум сүүлийн 3 жилийн хугацаанд 100 орчим аж ахуйн нэгжээс усны дүгнэлт, зөвшөөрөлгүй байхад 50.5 сая төгрөгийн усны төлбөрийн орлогыг бүрдүүлсэн,		Зөвлөмж
26		Манхан сум 0.4 сая, Зэрэг сум 0.5 сая, Чандмань сум 0.3 сая төгрөгийн ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг төсөвт байгууллагаас бүрдүүлсэн ба барилга, талх нарийн боов, уурын зуух, халуун ус, жуулчны бааз зэрэг ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд усны төлбөр ногдуулаагүй зэрэг зөрчлүүд байна.		Зөвлөмж
27	2.5.Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт төлөвлөсөн эсэх.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4.1.5-д ус рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар хуульчилсан. Гэтэл 17 сумдын ЗДТГ нь усны төлбөрөөс бүрдүүлсэн татварын орлогоос усны орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй, хуулийн хэрэгжилт хангагдаагүй байна.	36,700.0	Зөвлөмж
28	2.6.Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж, үр өгөөжтэй байгаа эсэх.	Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой хэрэглээг бий болгох бодлого зорилтын хүрээнд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээг хэт жижиглэн төлөвлөж зарцуулж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг төдийлөн бий болохгүй байна.		Зөвлөмж
29		Мянгад сумын Усны голдирол өөрчлөх, суваг шуудуу сэргээх, шинээр татах ажил: “БЭСА”ХХК-ны гүйцэтгэсэн 100.0 сая төгрөгийн өртөгтэй тус ажилд усны боолтыг сайжруулахаар өгөгдсөн үүргийг хэрэгжүүлээгүйгээс боолт сэтэрсэн,		Зөвлөмж

30		Буянт сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажил 69930.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил ажлын даалгаврын дагуу хийгдээгүй, ашиглагч байгууллага хүлээж авахаас татгалзсан,		Зөвлөмж
31	Усны тухай хуулийн 19.1.2-д “сум, дүүргийн байгаль хамгаалагч нь ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд нь хяналт тавих”, 19.1.4-д “энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх” гэж заасан байна.	Байгаль хамгаалагч нар мэргэжлийн бус, өөрийн ажил албан тушаалтай холбоотой хууль, дүрэм журмаа судалж ойлгоогүй, төлбөртэй холбоотой асуудал нь татварын байцаагчийн ажил мэтээр хандаж ажлын хариуцлага сул байна.		Зөвлөмж
32	Мөн Байгалийн нөөц ашигласны тухай хуулийн 23.1-д “сум дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажилуулна” гэж заасан байна.	Хууль тогтоомжууд хоорондоо уялдахгүйгээс сумын ЗДТГ, аймгийн БОАЖГ, Татварын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо муутайгаас ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна		Зөвлөмж
33	Сумдад байгаль хамгаалагч нар ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалтыг хийгээд татварын байцаагчид хүргүүлж, татварын байцаагч тухайн аж ахуйн нэгж байгууллагын нэр дээр нэхэмжлэх үүсгээд татварын программд шивж оруулж байгаа боловч 3 хоногын дотор төлбөрөө төлөхгүй бол тухайн нэхэмжлэх автоматаар устдаг байна.	Программын энэ үйлдлээс болж төлбөр бүрэн төлөглөхгүй, төлбөр төлүүлэх үүрэг эзэнгүйдэх нэг шалтгаан болж байна.		Зөвлөмж

34	Гурав: Хяналтыг чанартай үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх.	Төрийн байгууллагын усны бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтэц орон тоо хангалттай байгаа боловч салбар хоорондын ажлын уяалдаа холбоогүй, бодлого оновчтой бус тус тусдаа ажиллаж хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлэн ажиллахгүй байна. Сав газрын захиргаанд ажлын байрны тодорхойлолтод заасан орон тоон дээр усны мэргэжилийн бус хүн ажиллаж байна.		Зөвлөмж
35		Орон нутгийн хэрэглэгчдийг бүрэн тоолууржуулах шаардлагатай байна		Зөвлөмж
36		Аудитын төлөвлөлийн явцад аймгийн ИТХ-ын даргад Усны тухай хуулийн хэрэгжилтийн аудит хийгдэж байгаа тухай мэдэгдэл хүргүүлсэн боловч хяналт шалгалттай холбоотой ажил хийгдээгүй, хөтөлбөр батлаагүй, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хянадаггүй байна.		Зөвлөмж
НИЙТ ДҮН			513.301.2	

Монгол Улс, Ховд аймаг- 81140, Жаргалант сум

ЗДТГ-ын 3 давхар

Утас: 70433061, 70432545 Факс 70433061

Э-мэйл хаяг: khovd@audit.gov.mn

Вэбсайт:[audit.mn /khovd/](http://audit.mn/khovd/)